



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2003 оны 7 сарын 03 өдөр

Дугаар 272

Улаанбаатар хот

ТОГТООЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, Засгийн газрын 2003 оны 138 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байгаа 9 дүгээр сургуулийн хуучин барилга, “Тэмүүлэл” төвийн түрээсээр эзэмшиж байгаа байр”-ыг тэнэмэл амьдралтай иргэдийн түр хоноглох байр, “Амьдрах ухаан сургалт үйлдвэрлэлийн тусгай төв” болгон ашиглуулах асуудлыг 7 дугаар сарын 10-ны дотор шийдвэрлэхийг Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнаран/, дээрх барилгуудын засвар, өөрчлөлтийн зураг төсвийг боловсруулан их засвар хийж, энэ оны 10 дугаар сарын 1-ний дотор ашиглалтанд оруулахыг Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газар /М.Цэлмэг/-т тус тус даалгасугай.

3. “Түр хоноглох байр”, “Амьдрах ухаан-сургалт үйлдвэрлэлийн тусгай төв”-ийн ажиллах журам, бүтэц орон тоо, зохион байгуулалтыг 10 дугаар сарын 1-ний дотор боловсруулж батлуулан, байнгын үйл ажиллагаанд оруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс /Ш.Наран/, Хөдөлмөр нийгмийн хамгааллын алба /Д.Хулганаа/-нд тус тус үүрэг болгосугай.

4. “Амьдрах ухаан-сургалт үйлдвэрлэлийн тусгай төв”-ийн санхүүжилтийг жил жилийн төсөвт тусгаж, цаашид төсөл хэрэгжүүлэх, аж ахуйн тооцоон дээр ажиллуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг Санхүү, эдийн засаг, стратегийн бодлогын хэлтэс /Ч.Бат/, “Түр хоноглох байр”-ны үйл ажиллагааны санхүүжилтийг 2003 оны 4 дүгээр улирлаас эхлэн дүүргийнхээ Халамж үйлчилгээний төсөвт тусган хэрэгжүүлэхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга /Л.Найдан/-д тус тус даалгасугай.

5. Дулааны бүх павильон, цооногийг бэхлэх арга хэмжээ авч, тэнд орогнож буй тэнэмэл амьдралтай иргэдийг тухай бүр “Түр хоноглох байр”-нд шилжүүлж байхыг “Улаанбаатар дулааны сүлжээ” ХК /Ш.Баасанжав/, Цагдаагийн газар /Н.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Засгийн газрын 2003 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх дэд хөтөлбөр”, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, энэхүү захирамж, төлөвлөгөөний холбогдох заалт бүрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж, биелэлтийг хагас жил тутам Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байхыг дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.


7. Тэнэмэл амьдралтай зарим гэр бүлд олгох гэр, энгийн орон сууцны санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган батлуулж байхыг Санхүү, эдийн засаг, стратегийн бодлогын хэлтэс /Ч.Бат/-т даалгасугай.

8. Энэ захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан түүнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын орлогч Ч.Сумаахүүд даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2003 оны
27 дугаар захирамжийн хавсралт

**“ТЭНЭМЭЛ АМЬДРАЛТАЙ ИРГЭДИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХ
ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2003 ОНЫ
138 ДУГААР ТОГТООЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

1. Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 138 дугаар тогтоол, “Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх дэд хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс
2003 оны 6 дугаар сард

2. Дээрх тогтоол, хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг хариуцсан байгууллага, албан тушаалтнаар гаргуулан авч хяналт шинжилгээ, үнэлгээ хийж мэдээлж, хэрэгжилтийг эрчимжүүлж байх.

Хөдөлмөр, нийгэм хамгааллын алба
Хагас жил тутам

3. Дээрх тогтоол, хөтөлбөр, төлөвлөгөөг олон нийтэд сурталчлах, хэрэгжилтийн явц, үр дүнг тогтмол мэдээлж байх.

Улаанбаатар радио, сонин, телевиз
2003 оноос жил бүр

4. “Амьдрах ухаан-сургалт үйлдвэрлэлийн тусгай төв”-ийн байрны асуудлыг шийдвэрлүүлж, засвар үйлчилгээ хийж, ашиглалтанд оруулах.

Нийслэлийн Өмчийн харилцааны газар,
Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газар
2003 оны 10 дугаар сард

5. Сургалт үйлдвэрлэлийн тусгай төв байгуулах ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулахад шаардагдах эргэлтийн хөрөнгө, машин тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэх.

Санхүү, эдийн засаг, стратегийн бодлогын хэлтэс
Хөдөлмөр, нийгэм хамгааллын алба
2003 оны 2 дугаар улиралд

6. Сургалт үйлдвэрлэлийн тусгай төвийн орон тоо, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлийг гарган батлуулж, Сургалт үйлдвэрлэлийн тусгай төвийн үйл ажиллагааг эхлүүлэх.

2003 оны 4 дүгээр улиралд

7. Тэнэмэл амьдралтай боловч цаашид суралцах чадвар, сонирхолтой залуучуудыг зохих шатны сургуульд суралцахад нь дэмжлэг үзүүлэх.

Нийслэлийн Боловсролын газар

2003 оноос жил бүр

8. Тэнэмэл иргэдийн "Түр хоноглох байр"-ны асуудлыг шийдвэрлэж, засвар хийж ашиглалтанд оруулах.

Нийслэлийн Өмчийн харилцааны газар,

Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газар

2003 оны 3 дугаар улиралд

9. Түр хоноглох байранд тэнэмэл амьдралтай иргэдийг байрлуулах ажлыг зохион байгуулах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын

Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс,

Хөдөлмөр, нийгэм хамгааллын алба,

Дүүргийн Засаг дарга,

Цагдаагийн газар

2003 оны 4 дүгээр улиралд

10. Тэнэмэл амьдралтай зарим гэр бүлд тэдгээрийн гэр орноо авч явах чадварыг харгалзан гэр олгох ажлыг зохион байгуулах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,

Захирагчийн ажлын алба,

Хөдөлмөр, нийгэм хамгааллын алба,

Дүүргийн Засаг дарга,

Орон нутгийн орон сууц хөгжүүлэх сан

2003 оноос жил бүр

11. Гадаадын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдэд зориулан барилгын хямд төсөр материалыг ашиглан нийтийн орон сууц бариулах.

Захирагчийн ажлын алба,

Санхүү, эдийн засаг, стратегийн бодлогын хэлтэс

Дүүргийн Засаг дарга,

Орон нутгийн орон сууц хөгжүүлэх сан

2003-2006 он

12. Тэнэмэл амьдралтай иргэдээр нийтийг хамарсан ажил хийлгэх, орлогын эх үүсвэртэй болгох жижиг төслүүдэд хамруулах.

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зөвлөл

Хөдөлмөр, нийгэм хамгааллын алба,

Дүүргийн Засаг дарга,

Хөдөлмөр эрхлэлтийн албад

2003 оноос

13. Гэр, сууцаар хангасан өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулж, орлогын эх үүсвэртэй болгох ажлыг зохион байгуулах.

Хөдөлмөр, нийгэм хамгааллын алба,

Дүүргүүдийн Хөдөлмөр эрхлэлтийн алба

2003 оноос жил бүр

14. Нийтийг хамарсан ажилд тэнэмэл амьдралтай иргэдийг хамруулах.
Хөдөлмөр, нийгэм хамгааллын алба,
Дүүргүүдийн Хөдөлмөр эрхлэлтийн алба
2003 оноос
15. Тэнэмэл амьдралтай иргэдийг бичиг баримтжуулах, зөрчилгүй болгох.
Нийслэлийн Иргэний бүртгэл мэдээллийн алба
Цагдаагийн газар
2003 оны 3-4 дүгээр улиралд
16. Асран хамгаалагчгүй, бие даан амьдрах чадваргүй тэнэмэл иргэдийг улс, орон нутгийн асрамжийн төвд хүлээлгэж өгөх.
Дүүргийн Засаг дарга
Халамж үйлчилгээний төвүүд
2003 оны 4 дүгээр улирлаас
17. Улаанбаатар хотод байгаа дулааны шугам сүлжээний цооногуудыг хаах.
Нийслэлийн Захирагчийн ажлын алба
Цагдаагийн газар
“Улаанбаатар дулааны сүлжээ” ХК
2003 оны 3, 4-р улирлаас
18. Сэтгэцийн эмгэгтэй, архидах, мансуурах донтой тэнэмэл иргэдийн судалгааг гаргаж, эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах.
Хууль зүйн хэлтэс
Эрүүл мэндийн газар
Хөдөлмөр, нийгэм хамгааллын алба,
Цагдаагийн газар
Дүүргийн Засаг дарга
2003 оноос жил бүр
19. Архидах, мансуурах донтой тэнэмэл иргэдийг албадан эмчилгээнд хамруулах.
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
Цагдаагийн газар
Дүүргийн Засаг дарга
2003 оноос жил бүр
20. Тэнэмэл амьдралтай иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс
Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар
2003 оноос байнга